


Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн ректорын  
2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн  
№71 тоот тушаалын нэгдүгээр хавсралт



### СУРАЛЦАГЧ СУРАЛЦУУЛАХ ГЭРЭЭ /БАКАЛАВР/

Огноо # Улаанбаатар хот

Энэхүү суралцагч суралцуулах гэрээг нэг талаас Хүмүүнлэгийн Ухааны Их Сургууль (цаашид "Сургууль" гэх)-ийг төлөөлж Сургалтын албаны дарга Баяндүүрэн овогтой Урансайхан нөгөө талаас "....." хөтөлбөрт элсэн суралцагч ..... овогтой ..... (РД: .....) /цаашид "Суралцагч" гэх/ бид нар Дээд боловсролын тухай хууль, Иргэний хуулийн 42.3, 196, 206 дугаар зүйлүүдийг тус тус үндэслэн харилцан тохиролцож, сайн дурын үндсэн дээр дараах нөхцөлөөр байгуулав.

#### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү гэрээний зорилго нь талуудын хооронд дээд боловсролын зэрэг олгох сургалтын үйл ажиллагаатай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Суралцагч нь Сургуулийн "Суралцагч элсүүлэх журам", "Сургалтын журам", "Суралцагчийн ёс зүйн дүрэм", "Төлбөр тооцооны журам" болон бусад холбогдох дүрэм, журамтай эцэг, эх, харгалзан дэмжигчийн хамтаар танилцаж хүлээн зөвшөөрсөн болно.

#### Хоёр. Суралцагчийн эрх, үүрэг

Суралцагч дараах эрхтэй:

- 2.1. Суралцах орчин, нөхцөлөөр хангуулах;
- 2.2. Суралцагч өөрийн суралцаж буй хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөнд заасан хичээлээс гадна хуваарь давхцаагүй нөхцөлд бусад хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөний хичээлүүдээс сонгон судлах;
- 2.3. Сургуулиас тухайлан заасан хичээлийг бие даан судалж, дүгнүүлэх;
- 2.4. Сургалт болон бусад үйлчилгээтэй холбогдох асуудлаар албан хүсэлт гаргах;
- 2.5. Сургуулийн "Төлбөр тооцооны журам"-д заасны дагуу хөнгөлөлт эдлэх;
- 2.6. Эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлэх, хуралд оролцохоор бүтээлээ дэвшүүлэх;
- 2.7. Сургалтын үйл ажиллагаатай холбоотой асуудлыг хэлэлцэх, шийдвэрлэхэд шууд буюу төлөөлөн оролцох;
- 2.8. Боловсролын зээлийн сангаас тавигдах шаардлагад нийцэж буй тохиолдолд оюутны хөгжлийн зээл, буцалтгүй тусламжид хамрагдах;

Суралцагч дараах үүрэгтэй:

- 2.9. Сургалтын болон зүй ёсны шаардлагыг биелүүлэн хичээлд бүрэн хамрагдаж, шалгалт, даалгавар, дадлага, төгсөлтийн ажлыг хугацаанд нь гүйцэтгэн, хоцрогдолгүй хариуцлагатай бие даан амжилттай суралцах;

- 2.10. Суралцагч өөрийн суралцаж буй хөтөлбөрийн санал болгох төлөвлөгөөний дагуу ганцаарчилсан төлөвлөгөөг улирлын 17 болон 18-р долоо хоногт зөвлөх багшийн хамт хянан баталгаажуулж, улирал дутам өөрийн судалсан багц цаг, дүнгийн бүртгэлийг хянан "Сургалтын журам"-ын заасан хугацаанд зохих өөрчлөлтийг оруулан баталгаажуулах;
- 2.11. Суралцагч энэхүү журмын 2.10 заалтыг биелүүлээгүйгээс гарах үр дагаврыг бүрэн хариуцах бөгөөд ХИС-ийн "Сургалтын журам"-д заасны дагуу боломжит улиралд нөхөн судлах;
- 2.12. Сургуулийн дүрэм, журам, бусад холбогдох мэдээлэл, заавартай танилцан мөрдлөг болгон бусдын эрх ашгийг хүндэтгэн, ёс зүйн зарчмыг баримтлан сургалтын үйл ажиллагаанд идэвх санаачилгатай оролцох;
- 2.13. Сургалтын үйл ажиллагаанд оролцоход шаардлагатай хувийн бэлтгэлийг бүрэн хангаж бие даан оролцох;
- 2.14. Суралцах хугацаанд эрүүл мэндийн даатгалд бүрэн хамрагдах;
- 2.15. Сургалтын төлбөр болон холбогдох үйлчилгээний хураамжийг заасан хугацаанд төлөх;
- 2.16. Сургалтын үйл ажиллагаанд оролцоход шаардлагатай баримт бичгийг заасан хугацаанд холбогдох албанд хүлээлгэн өгөх;
- 2.17. Өөрийн буруутай үйлдлийн улмаас Сургуулийн орчинд болон сургалтын хэрэглэгдэхүүнд аливаа хохирол учруулсан тохиолдолд хохирлыг тухайн үеийн зах зээлийн ханшаар бүрэн барагдуулах;
- 2.18. Багш, ажилтан, бусад суралцагчтай ёс зүйн хэм хэмжээг баримтлан харилцах;
- 2.19. Суралцах хугацаандаа гүйцэтгэсэн судалгааны ажил, эрдэм шинжилгээний бүтээл, төслийн ажлуудад ёс зүйн баталгаа гаргаж өгөх;
- 2.20. Сургуулийн үйл ажиллагаа, бусдын нэр хүндэд үндэслэлгүй, хууль бусаар халдахгүй байх;

### **Гурав. Сургуулийн эрх, үүрэг**

Сургууль дараах эрхтэй:

- 3.1. Сургуулийн "Сургалтын журам"-ын шаардлага бүрэн хангасан суралцагчид зохих боловсролын зэрэг, сургалтын гэрчилгээ олгох;
- 3.2. Сургалтын агуулга, арга, хэлбэр, судалгаа, туршилтын ажлын зорилт, чиглэл, тэдгээрийг шийдвэрлэх арга замыг шинэчлэн хэрэгжүүлэх;
- 3.3. Инфляц болон зардлын төсвийг харгалзан тухайн хичээлийн жилийн сургалтын төлбөрийн нэг багц цагийн үнэлгээнд өөрчлөлт оруулах;
- 3.4. Бүлэг бүрдэлтээс хамаарч хичээлийн хуваарьт өөрчлөлт оруулах, хөтөлбөр, хичээлийн хэрэгжилтийг цуцлах;
- 3.5. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр заасан хугацаанд хичээлийн бүртгэлд хамрагдаагүй эсвэл идэвх санаачилгагүй, хангалтгүй сургалтын үйл ажиллагаанд оролцсон суралцагчийг зохих журмын дагуу чөлөөлөх;
- 3.6. Суралцагчийн судалгааны болон төслийн ажлыг хэвлэмэл болон цахим хэлбэрээр номын санд байршуулж, нийтийн хүртээл болгох, сургалтад ашиглах;

- 3.7. Монгол Улсын хууль, тогтоомж болон Сургуулийн дүрэм, журам, ёс зүйн хэм хэмжээг ноцтой зөрчсөн суралцагчийг бүрэн чөлөөлж дахин гэрээ байгуулахаас татгалзах;
- 3.8. Суралцагчаас энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах;
- 3.9. Сургалтын төлбөр, хураамж хугацаанд нь төлөөгүй тохиолдолд сургалтын үйл ажиллагаанд оролцох эрхийг хязгаарлах, гэрээг цуцлах;
- 3.10. Суралцагч энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд сургалтын үйл ажиллагаанд оролцох, үйлчилгээ авах эрхийг хязгаарлах, гэрээг дуусгавар болгох;

Сургууль дараах үүрэгтэй:

- 3.11. Сургалтад шаардагдах орчин, нөхцөлөөр хангах;
- 3.12. Сургалт болон бусад үйлчилгээтэй холбогдох асуудлаар санал хүсэлт, хүлээн авч шийдвэрлэх;
- 3.13. Сургуулийн төлбөр тооцооны журмын дагуу хөнгөлөлт үзүүлэх;
- 3.14. Сургуулийн дүрэм, журам болон бусад холбогдох мэдээлэл, заавартай танилцах боломжоор хангах;
- 3.15. Эрдэм шинжилгээний сэтгүүл нийтлэх, хурал зохион байгуулах;
- 3.16. Суралцагчийг сургалтын үйл ажиллагаатай холбоотой асуудалд шууд буюу төлөөлөн оролцуулах;

#### **Дөрөв. Сургалтын төлбөр, хураамж**

- 4.1. Суралцагч нэхэмжлэхийн нөхцөлийн дагуу төлбөр, хураамжийг хугацаанд нь бүрэн төлнө.
- 4.2. Тухайн улиралд судлах хичээлийн нийт багц цагийн төлбөрийг "Төлбөр тооцооны журам"-ын 3.2.2-т заасан хуваарийн дагуу харгалзах хувиар тооцож төлнө.
- 4.3. Суралцаж буй суралцагч хичээлийн жилийн улирал эхэлснээс хойш хүсэлт гаргасан тохиолдолд, хүсэлт гаргасан өдрөөр тасалбар болгон суралцсан хугацааны сургалтын төлбөрийг суутгуулан, тухайн улирлын суралцаагүй үлдсэн хугацааны төлбөрийн 90%-ийг буцааж олгоно. Тухайн улирлын төлбөрөөс илүү төлсөн төлбөрийг 100% буцааж олгоно.
- 4.4. Жилийн чөлөө авсан суралцагч суралцсан хугацааны төлбөрөөс илүү төлөгдсөн сургалтын төлбөрөө буцаан авах хүсэлт гаргасан тохиолдолд суралцсан хугацааны төлбөрийг суутгуулан, үлдсэн хугацааны төлбөрийн 90%-ийн төлбөрийг буцааж олгоно.
- 4.5. Чөлөө авах, сургуулиас чөлөөлөгдөх албан хүсэлт өгөөгүй, хүндэтгэн үзэх шалтгаангүй хичээлд хамрагдаагүй тохиолдолд хичээлд хангалтгүй оролцсонд тооцож буцаан олголт хийхгүй.
- 4.6. Сургуулийн зүгээс шалтгаалан сургалт зохион байгуулагдаагүй тохиолдолд сургалтын төлбөрийг 100% буцаан олгоно.
- 4.7. Суралцагч үргэлжлүүлэн суралцахдаа тухайн хичээлийн жилд мөрдөгдөж буй нэг багц цагийн үнэлгээгээр тооцож сургалтын төлбөрийг төлнө.

### **Тав. Давагдашгүй хүчин зүйлс**

- 5.1. Талууд тэдгээрийн хяналтаас гадуур, урьдчилж тооцох ба даван туулах боломжгүй, төрөөс гаргасан шийдвэр, гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй /дайн байлдаан, тахалт өвчин, цар тахал, байгалийн гамшиг, гал түймэр, дэлбэрэлт, үймээн самуун г.м/ нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй эсвэл саатсан тохиолдолд давагдашгүй хүчин зүйл үргэлжлэх хугацаанд талууд харилцан бие биеийнхээ эсрэг шаардлага гаргах, хөөн хэлэлцэх хугацаа түр зогсоно.
- 5.2. Давагдашгүй хүчин зүйлд өртсөн тал гэрээний үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болсон тохиолдолд үүнээс гарах үр дагавар болон гэрээг хамгийн бага хугацаагаар хойшлуулах бүх арга хэмжээг авна.

### **Зургаа. Бусад зүйлс**

- 6.1. Суралцагч энэхүү гэрээний агуулгыг хүлээн зөвшөөрч цахим хэлбэрээр баталгаажуулан сургалтын төлбөр, хураамжийг тус гэрээний 4.1-т заасны дагуу бүрэн төлж, гэрээг гарын үсгээр баталгаажуулсан өдрөөс хүчин төгөлдөр болно.
- 6.2. Боловсролын зээлийн сангаас санхүүжигдэх буцалтгүй тусламжид хамрагдах тохиолдолд Боловсролын зээлийн сангаас баталгаажуулалт хийхээс өмнөх сургалтын төлбөр болон санхүүжилтээс давсан төлбөрийг суралцагч өөрөө хариуцна.
- 6.3. Гэрээний хугацаа 48 сар байна.
- 6.4. Суралцагч төлбөр, хураамжийг Сургуулийн "Төлбөр тооцооны журам"-ын 3.2.2-т заасан хугацаанд төлөөгүй сургалтын үйл ажиллагаанд оролцох, үйлчилгээ авах эрхийг төлбөр, хураамж төлөх өдөр хүртэл хязгаарлана.
- 6.5. Энэхүү гэрээний 6.4-д заасан хугацаанд төлбөр, хураамж төлөөгүй ажлын 5 хоног болсон тохиолдолд энэхүү гэрээг дуусгавар болгож мэдэгдэл хүргүүлнэ.
- 6.6. Гэм буруутай нь хуулийн байгууллагаар тогтоогдсон тохиолдолд тухайн өдрөөр гэрээ дуусгавар болно.
- 6.7. Гэрээнд тусгагдаагүй аливаа асуудлыг Боловсролын ерөнхий хууль, Иргэний хууль, Сургуулийн дүрэм, журам, бусад холбогдох хууль тогтоомжийг баримтлан шийдвэрлэнэ.
- 6.8. Талуудын хооронд гэрээнд заасан асуудлаар маргаан гарвал эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд хэрэв талууд тохиролцоонд хүрээгүй тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 6.9. Суралцагч гэрээний нэг хувийг Сургалтын албанд хүлээлгэн өгч, нэг хувийг өөрт хадгална.
- 6.10. Гэрээг хоёр хувь үйлдэх ба хэвлэмэл болон цахим хувь тус бүр нэгэн адил хүчин төгөлдөр байна.

**Сургуулийг төлөөлж:**

Сургалтын албаны дарга:  
Б.Урансайхан

Хаяг: СБД, 8-р хороо,  
Сүхбаатарын талбай-20

Утас: 77111500 /150-155/

**Гарын үсэг:**

**Суралцагчийг төлөөлж:**

Овог, нэр:

Хаяг:

**Гарын үсэг:**

Утас:

*Суралцагч нь насанд хүрээгүй /18 нас/ тохиолдолд*

Эцэг, эх, харгалзан дэмжигчийн овог нэр:

Регистрийн дугаар:

Утас:

**Гарын үсэг:**

